

БАЙГУУЛЛАГЫН 2025 ОНЫ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ
ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН
“ТАЙЛАНГИЙН МАЯГТ”

2026.01.07

Орхон аймаг

НЭГ. Товч танилцуулга

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, хамт олныг соён гэгээрүүлэх, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил зохион байгуулах чиг үүрэг бүхий байгууллагын ёс зүйн дэд хороог хамт олны санал хураалтын дүнг үндэслэн газрын даргын 2024 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн А/11 дүгээр тушаалаар 3 албан хаагчийн бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулсан.

Байгууллагын ёс зүйн дэд хороо нь 2025 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг газрын даргаар батлуулж, нийт 5 чиглэлийн хүрээнд 11 арга хэмжээг төлөвлөснөөс байгууллагын болон ёс зүйн дэд хорооны гишүүдийг чадавхжуулах сургалт, аян зохион байгуулах, мэдээллийн самбарыг тогтмол баяжуулан ажиллах зэрэг 11 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж, хэрэгжилт 100 хувьтай байна.

Мөн ёс зүйн цахим системд төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг байгууллагын ёс зүйн дэд хорооны нарийн бичиг цаг хугацаанд нь тайлагнан ажиллаж байна. Тайлант хугацаанд ямар нэгэн ёс зүйн зөрчил гараагүй болно.

Газрын даргын 2024 оны А/25 дугаар тушаалаар шинэчлэн баталсан “Хүнс, хөдөө аж ахуйн газрын хөдөлмөрийн дотоод журам”-д Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн хүрээнд заасан төрийн албан хаагчийн баримтлах ёс зүйн хэм хэмжээг мөрдөж ажиллах талаар тусгасан.

Төрийн үйлчилгээний 5 албан хаагчийн хөдөлмөрийн гэрээг шинэчлэн боловсруулсантай холбогдуулан төрийн албан хаагчийн ёс хэм хэмжээг баримтлан ажиллах, албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хулийн хэрэгжилтийг мөрдөн ажиллах талаар тус тус тусган батлуулсан.

ХОЁР. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар

2.1. Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, хамт олныг соён гэгээрүүлэх, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор байгууллагын ёс зүйн дэд хорооноос 1 удаагийн танхимын, 1 удаагийн цахим сургалт, 1 удаагийн аян зохион байгуулж, ёс зүйн мэдээллийн самбарыг шинээр хийж, тухай бүр мэдээллийг шинэчлэн ажилласан.



2.2. Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал:

Манай байгууллагын томилох эрх бүхий албан тушаалтан нь төрийн албанд шударга, хариуцлагатай, ил тод засаглалыг төлөвшүүлэхэд манлайлан ажилладаг. Томилгоо, шийдвэр бүр нь хууль, журамд нийцсэн, ашиг сонирхлын зөрчилгүй, байгууллагын ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааг дэмжиж, хараат бус байдлыг хангаж ажилладаг.

2.2. Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал:

1. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр, байгууллагын ёс зүйн дэд хорооны 2025 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллах хүрээнд Ойн мандах ёс зүйн академитай хамтран “Байгууллагын соёл ба ажилтнуудын ёс зүй” сэдэвт анхан шатны багц сургалт, Аймгийн ЗДТГазрын Хууль, эрх зүйн хэлтэстэй хамтран Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ зэрэг хууль тогтоомжийн чиглэлээр 3 удаагийн сургалтыг зохион байгуулж, нийт 23 албан хаагч буюу 100 хувь хамруулан, хууль, байгууллагын соёл, ёс зүйн талаарх мэдлэгийг олгосон. 2. Байгууллагын ёс зүйн дэд хороог чадавхжуулах сургалтыг авч, дэд хорооны 3 гишүүнийг чадавхжуулав. 3. Ойн мандах Ёс зүйн академитай хамтран албан хаагчдаас 1 удаагийн сэтгэл ханамжийн судалгаа, 4. Албан хаагчдын дунд хууль, эрх зүйн чиглэлээр танин мэдэхүйн АХА тэмцээнийг 1 удаа, 5. Албан хаагчдад хууль, эрх зүйн мэдлэг олгох чиглэлээр гарын авлага бэлтгэн хүргэх ажлыг 1 удаа, 6. Хүнс, хөдөө аж ахуйн газрын албан хаагчдын дотооддоо мөрдөн ажиллах ёс зүйн дүрмийг боловсруулан батлуулсан, 7. Хамт олны зэрэг уур амьсгалыг бүрдүүлэх зорилгоор “Талархлын аян”-ыг 7 хоногийн хугацаатай нийт албан хаагчдыг хамруулан зохион байгуулж, хамгийн олон талархал авсан 1 албан хаагчийг дурсгалын зүйлээр урамшуулан шагнав. 8. Байгууллагын ёс зүйн дэд хорооны 3 дугаар улирлын цахим тайланг илгээсэн. 9. Монгол Улсын Ёс зүйн хорооны 2025 оны 06 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг тооцох үнэлгээний аргачлал”-ын дагуу байгууллагын нийт албан хаагчдаас төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг үнэлгээний хуудсаар авч, дүгнэлт, зөвлөмж гарган ажиллав.	
Гарсан үр дүн, ололт амжилт:	Бэрхшээл:
Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, ёс зүйн хэм хэмжээ, байгууллагын соёлын чиглэлээр 3 удаагийн сургалтад нийт албан хаагчдын 100 хувь (23 албан хаагч) хамрагдсан нь хууль, ёс зүйн талаарх мэдлэгийг жигд түвшинд хүргэх чухал үр дүн болсон. Сургалтаар албан хаагчид ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөв хандлага төлөвшүүлэх практик ойлголт авсан. Ёс зүйн дэд хорооны гишүүдийг чадавхжуулах сургалтад хамруулснаар хууль, журам хэрэгжүүлэх, зөвлөмж боловсруулах, эрсдэлийг тодорхойлох мэдлэг чадвар дээшилсэн. Дэд хороо өөрийн чиг үүргийг илүү бие даан, тогтолцоотой хэрэгжүүлэх боломж бүрдсэн.	Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх арга хэмжээнүүдийг зохион байгуулахад төсөв мөнгө батлагдаагүй тул хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байдаг.
Санал: Төрийн албан хаагчдын ёс зүйн мэдлэг, хандлагыг дээшлүүлэх сургалт, хэлэлцүүлэг, судалгаа, соён гэгээрүүлэх ажлыг тогтмол, чанартай зохион байгуулах зорилгоор жил бүрийн төсөвт тусгай зардлын багц нээж санхүүжилт олгох.	

БАТАЛГААЖУУЛАЛТ:

БАЙГУУЛЛАГЫН ЁС ЗҮЙН ДЭД
ХОРООНЫ ДАРГА

ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Ц.ГАНХУЯГ

М.ЁНДОНСАМБУУ